

**ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТАН, АЛБА
ХААГЧИЙГ СУРГАЖ БЭЛТГЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ
АСУУДАЛ**

**SOME PROBLEMS IN THE TRAINING OF LEADERS AND OFFICERS OF
DOMESTIC INTERNAL TROOPS ORGANIZATIONS**

Б.Ариунтөгс

Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Дотоодын
цэргийн албаны тэнхимийн багш,
ахлах дэслэгч

Хураангуй: Энэхүү өгүүлэлд дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтныг сургаж, бэлтгэхэд тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

Abstract: This article, the domestic internal troops managerial level officer is trained, some of the problems facing the preparation are identified and written.

Түлхүүр үгс: Дотоодын цэргийн удирдах ажилтан, сургалт бэлтгэл, асуудал

Keywords: Internal troops managerial officers, skill, training, some problems

Оршил

Өндөр үр бүтээлтэй, урдаа тавьсан зорилго, зорилтдоо хүрэхийн төлөө байгууллага нь хүний нөөцийн оновчтой уян хатан, тасралтгүй нөхөгдөх бодлого явуулах нь чухал. Өөрөөр хэлбэл хүний нөөцийг удирдах хэлтэс хэдий чинээ сайн ажиллана байгууллагын амжилт түүнээс шууд хамааралтай байдаг бөгөөд аливаа байгууллагын хамгийн чухал нөөц бол хүн гэдэг нь зайлшгүй юм.

Иймээс байгууллагын ажилчдын мэдлэг, ур чадвар, хөгжил болон тогтвор суурьшилтай ажиллах зэрэг нь тухайн байгууллагын амжилтын үндэс болдог. Үүний тулд хүмүүсийг зөв удирдан чиглүүлж, ажилтан алба хаагчаа хөгжүүлж чадвал тэд үр ашигтай ажиллаж түүнийхээ хэрээр хөгжиж, сэтгэж, бүтээлч сэтгэлгээтэй болдог байна.

Ямар нэгэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, тэрчлэн хувь хүний ололт, амжилт, тухайн байгууллагын хувь заяа, цаашдын ирээдүй, нийгэмд эзлэх байр суурь зэрэг бүхий л зүйл удирдан манлайлагчаас шууд хамааралтай байх бөгөөд энэхүү утгаараа удирдах албан тушаалтны гаргаж буй шийдвэрээс хамаарч байгууллагын цаашдын хөгжил чиг хандлага, хөгжил дэвшил тодорхойлогддог гэж ойлгож болно.

Өнөө цагийн нийгмийн хэрэгцээ, шаардлага, чөлөөт өрсөлдөөний энэ цаг үед удирдах албан тушаалтан ёс зүйтэй байж, удирдахуйн ухаанд суралцаж, харилцааны ур чадвар, бусдад нөлөөлөх чадвар, баг хамт олноо удирдах, зөв шийдвэр гаргах зэрэг чадваруудыг зайлшгүй эзэмших шаардлагатай болж байгаа бөгөөд удирдах албан тушаалтныг сургаж, бэлтгэж хөгжүүлэн дэвшүүлэх нь бүхий л байгууллагын хүний нөөцийн чухал асуудал болоод байна.

Үндсэн хэсэг

Дотоодын цэргийн байгууллага нь түүхэндээ байгуулагдсан цагаасаа буюу 1922 оноос Дотоодыг хамгаалах газар, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Хилийн ба Дотоодын цэргийн удирдах газар зэрэг байгууллагын харьяанд үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Харин 1990 онд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн үед улс орны дотоодод гарсан үймээн самуун, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсооход Хилийн цэргийн хүч хэрэгслийг татан оролцуулах боломжгүй, хууль эрх зүйн үндэс байхгүй хэмээн үзэж энэхүү үүрэг нь Дотоодын цэргийн чиг үүрэг тул Хилийн цэргийн харьяаллаас гаргаж, Цагдаагийн байгууллагын харьяалалд шилжүүлсэн байна.

Хууль эрх зүйн орчинг сайжруулах, зорилгоор “Дотоодын цэргийн тухай” хуулийг 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсанаар гүйцэтгэх чиг үүрэг болон хууль эрх зүйн орчин шинээр бүрдэн бий болсон.

Энэхүү хууль нь 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл даган мөрдөгдөж байсан бөгөөд Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Дотоодын цэргийг татан буулгаж, орон тоо, техник хэрэгсэл, төсөв зардал, хэрэгжүүлж байсан чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд 2017 оны 02 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас “Дотоодын цэргийн тухай хууль”-ийг баталж, Дотоодын цэргийн гүйцэтгэх чиг үүрэг, эрх зүйн үндсийг хуульчлан баталж, 2022 онд уг хуулийг шинэчлэн баталсан.

Нийгмийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдсөн буюу 1990-ээд оны эхэн үеээс төрийн байгууллагад ажиллагсдын цалин хөлс, ахуй хангамж хүрэлцэхгүй, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн зэргээс шалтгаалан алба хаагчид ажлаасаа гарах, ганзгын наймаа эрхлэх, өөр бусад шалтгааны улмаас хүний нөөцийн хомсдолд ихээхэн орж байсан байна.

Шинэ бүтэц зохион байгуулалтад шилжиж цагдаагийн байгууллагын харьяанд ажиллах нь дотоодын цэргийн алба хаагчдын хувьд шинэ соргог зүйл байсан бөгөөд тухайн цаг үед цэргийн алба хаагчидтай ажиллах залуу дарга нар, тусгай салбаруудад шинээр бүрдэж байгаа ахлагч нартай ажиллах туршлагатай офицерууд ихээхэн шаардагдаж байсан тул ажиллаж байсан туршлагатай алба хаагчдаас дэвшүүлэн томилох, зэвсэгт хүчин, хилийн цэргийн байгууллагуудаас олон арван боловсон хүчнийг шилжүүлэн томилж байжээ.

Дотоодын цэрэг нь улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн сацуу гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагад туслах чиг үүргийг гүйцэтгэдэг нь зэвсэгт хүчин, хилийн цэргээс ялгаатай учир удирдах албан тушаалтны хувьд цэргийн мэргэжлийн, эсхүл цагдаагийн мэргэжлийн хүнээр удирдуулах нь төдийлөн оновчтой сонголт биш гэж харагдаж байна.

Иймээс боловсон хүчнийг шилж сонгох, албанд дэвшүүлэн томилох, чадавхжуулах талаар Дотоодын цэргийн удирдлага тодорхой зорилтыг дэвшүүлсэн ба үүний үр дүнд Цагдаагийн дээд сургуульд дотоодын цэргийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх түүхэн шийдвэр гарч “Дотоодын цэргийн ажил-эрх зүй” мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэнээр 1999 оны хичээлийн жилээс эхлэн анхны 30 сонсогчийг элсүүлэн суралцуулж, 2003 онд шинэ үеийн дотоодын цэргийн боловсон хүчин болох 19 офицерыг зохих албан тушаалуудад томилжээ.

Удалгүй 5 жилийн дараа буюу 2008 онд¹ Цагдаагийн академид “Дотоодын цэргийн албаны тэнхим”-ийг байгуулсан байна.

Тэр цагаас хойш нэршил, бүтцийн хувьд:

- 2011 онд Цагдаагийн сургуулийн “Дотоодын цэргийн албаны тэнхим”;
- 2012-2017 онд Хилийн сургуулийн “Хилийн ба Дотоодын цэргийн эрдмийн тэнхим”;
- 2014 онд Цагдаагийн сургуулийн “Галын бэлтгэл, тусгай тактикийн тэнхим”;
- 2017 онд Цагдаагийн сургуулийн “Албаны тусгай бэлтгэлийн тэнхим”
- 2019 онд Цагдаагийн сургуулийн “Дотоодын цэргийн албаны тэнхим” болон тус тус өөрчлөгдөн шинэчлэгдэж, “Дотоодын цэргийн ажил-эрх зүй²”, “Аюулгүй байдал-Дотоодын цэрэг³”, “Дотоодын цэрэг судлал⁴” бакалаврын сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулж байна.


Хүснэгт 1. Дотоодын цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа офицеруудын төгссөн сургуулийн судалгаа.

¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны “Цэргийн албаны бүтэц, орон тоо батлах тухай” 568 дугаар тушаал.

² БСШУ-ны сайдын 2010 оны 235 дугаар тушаал.

³ Мөн сайдын 2014 оны А/78 дугаар тушаал.

⁴ БШУ-ны сайдын 2022 оны А/160 дугаар тушаал.



Эх сурвалж: “Хууль зүй, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын боловсролын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Г.Мэндбаяр “Дотоодын цэргийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж буй өнөөгийн байдал, чиг хандлага” УБ. 2022. 599 дэх тал.

Дээрх судалгаанаас үзэхэд нийт офицеруудын 14 хувь нь дотоодын цэргийн мэргэжилтэй офицер байгаа нь учир дутагдалтай байна. Шалтгаан нөхцлийг тодруулахад Дотоодын цэргийн байгууллага нь 2014 онд татан буулгах, 2017 онд Засгийн газрын шийдвэрээр буцаан байгуулагдахад боловсон хүчний хямралд орсон гэж үзэж болох талтай.

Гэхдээ нийт офицеруудын 50-иас дээшгүй хувь нь дотоодын цэргийн мэргэжлээр төгсөн, дотоодын цэргийн аль нэг анги, байгууллагад томилогдон ажиллах нь хүний нөөцийн бодлого хангагдах үндэс болох юм.

Дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтан гэж дотоодын дотоодын цэргийн дарга, дотоодын цэргийн штабын дарга, дэд дарга, дотоодын цэргийн штабын газар, хэлтсийн дарга, нар, анги байгууллагад ангийн захирагч, штабын дарга, захирагчийн орлогч, салбарын дарга нар, тусгай салбарт, тусгай салбарын захирагч нарыг тус тус ойлгоно.

Дотоодын цэргийн удирдах албан тушаалтныг гадаад, дотоодын сургууль, дамжаа, урт, богино хугацааны сургалтад хамруулж байгаа ч энэ нь төдийлөн хангалттай түвшинд хүрэхгүй байна гэж үзэж байна. Тухайлбал:

Дотоодын цэргийн удирдах албан тушаалтнууд нь удирдахуйн ухаан, цэргийн шинжлэх ухаан, хууль зүйн ухааны болон бусад чиглэлийн магистр болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшиж байгаа боловч дотоодын цэрэг судлалын чиглэлээр мэргэшсэн алба хаагч нэгээхэн ч байхгүй байна.

Батлан хамгаалахаас бусад үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагууд буюу Хил хамгаалах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Цагдаа,

Онцгой байдлын болон Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын магистр, докторын /удирдах албан тушаалтны/ хөтөлбөрийг Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академи хэрэгжүүлж байна.

Удирдлагын академи нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу “Хууль сахиулах удирдлага /F10320103/” докторын, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрээр “Хууль сахиулах удирдлага” докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхийг баталгаажуулсан.

“Хууль сахиулах удирдлага /E10320103/” судалгааны магистрын зэрэг олгох, “Цагдаагийн стратеги-тактик, удирдлага /E10320104/”, “Хилийн стратеги-тактик, удирдлага /E10380202/”, “Онцгой байдлын стратеги-тактик, удирдлага /E10320502/”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага/E10320201/” мэргэжлүүдээр магистрын зэрэг олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээрх мэргэжлүүдээр үндсэн ангид захиалагч агентлаг, байгууллагуудын удирдах албан тушаалын нөөц бүрдүүлэх бодлогын хүрээнд суралцагчдыг сонгон шалгаруулалтаар элсүүлэн 2 жилийн хугацаанд ажлаас чөлөөлөн өдрөөр сургаж “Цагдаагийн стратеги-тактик, удирдлага”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага”, “Онцгой байдлын стратеги-тактик, удирдлага”, “Хилийн стратеги-тактик, удирдлага”-ын мэргэжлийн диплом болон удирдахуйн ухааны магистрын зэрэг хамгаалуулан хос дипломтойгоор төгсгөдөг¹.

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академи нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 140 дүгээр тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, шүүхийн шинжилгээний болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах албан тушаалтныг үе шаттай бэлтгэх, давтан, мэргэшүүлэн сургах зорилготой байгуулагдсан бөгөөд өдгөө мэргэжлийн 6 профессорын багийн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. ДХИС-ын УА-ын профессорын баг

¹ <https://www.uia.gov.mn/>



Дээрх 6 тэнхим нь тус тус байгууллагын алба хаагчдад чиглэсэн сургалтыг зохион байгуулдаг ба “Дотоодын цэргийн стратеги, тэнхим”-ийг зайлшгүй байгуулах шаардлагатай байна.

Дотоодын цэргийн удирдах албан тушаалтанд зориулсан магистр, докторын сургалтыг зохион байгуулахад дээрх баг зайлшгүй шаардлагатай бөгөөд дотоодын цэргийн байгууллагад тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, арилгах, судалгаа, дүн шинжилгээ хийх, нийгэмд гарч буй өөрчлөлтөд дасан зохицоход нь туслах, мэргэжлийн статусыг дээшлүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

Байгуулагдснаас хойшх хугацаанд магистрын сургалтад 195 удирдах албан тушаалтныг суралцуулж төгсгөсөн боловч тус сургалтад дотоодын цэргийн нэг ч алба хаагч хамрагдаагүй байна. Энэ нь дотоодын цэргийн удирдах албан тушаалтныг бэлтгэх хүний нөөцийн бодлого дутмаг, сургалтын эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйтэй холбон ойлгож болох юм.

Монгол Улсын БШУЯ-ны сайдын 2022 оны тушаалд¹ “Дотоодын цэрэг судлал²” бакалавр, докторын сургалтын хөтөлбөртэй байхаар тусгажээ. Өөрөөр

¹ БШУЯ-ны сайдын 2022 оны А/160 дугаар тушаал.

² Мөн сайдын /хөтөлбөрийн нэр/ индекс шинэчлэн батлах тухай дээрх тушаалаар батлагдсан.

хэлбэл “Аюулгүй байдал-Дотоодын цэрэг” бакалаврын хөтөлбөрийг “Дотоодын цэрэг судлал” болгон өөрчилснөөр бакалавр, магистр, доткторын сургалтын хөтөлбөртэй болсон.

Энэ нь Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академид “Дотоодын цэргийн стратеги-тактик удирдлага” мэргэжлийн дипломын сургалт явуулах эрх зүйн орчин бүрдсэн гэж ойлгож болохоор юм.

Тус хөтөлбөр батлагдснаас хойш багагүй хугацаа өнгөрсөн ч ямар нэгэн ахиц дэвшил гараагүй, ажил огт хийгдээгүй байгаа бөгөөд орон тоо, төсөв хөрөнгө, багшлах боловсон хүчин зэрэг хүчин зүйлүүд тодорхой хэмжээнд хамаарна.

Дотоодын цэргийн байгууллагаас 2023 оны байдлаар ОХУ-д 2, ҮБХИС-ийн Удирдлагын академид 1, нийт 3 удирдах албан тушаалтан суралцаж байна.

Батлан хамгаалах салбараас бусад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагын удирдах албан тушаалтныг бэлтгэх чиг үүрэг бүхий сургалтын байгууллага буюу Дотоод хэргийн их сургуульд дотоодын цэргийн удирдах албан тушаалтныг сургаж, бэлтгэх эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

Иймд цаашид Дотоодын цэргийн штаб, Дотоод хэргийн их сургуулиас хамтарсан ажлын хэсэг байгуулж, дотоодын цэргийн удирдах албан тушаалтныг бэлтгэх магистр, докторын хөтөлбөрийг хамтран боловсруулж, Хууль, зүй дотоод хэргийн яам болон бусад холбогдох байгууллагад дээрх асуудлыг уламжлан багшлах бүрэлдэхүүн, орон тоо, бүтэц зохион байгуулалтын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Энэхүү магистр, докторын хөтөлбөрөөр Дотоодын цэргийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг болон хуулиар хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн алба хаагчдыг сургаж, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажил хийх, түүндээ тулгуурлан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, шийдвэр гаргах ур чадвартай мэргэжилтэн, удирдах албан тушаалтныг бэлтгэх юм.

Мөн гадаад улсын туршлагыг судлах зорилгоор үндэсний гвард, жандармери, карабинери, олон нийтийг хамгаалах хүчин зэрэг ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад алба хаагчийг урт болон богино хугацааны сургалтад хамруулах шаардлагатай бөгөөд алба хаагчийн гадаад хэлний түвшинг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд бүтэн жилийн хугацаанд зохион байгуулагдах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаар жил бүр батлуулан

хэрэгжилтийг ханган ажилладаг боловч дотоодын цэргийн дунд болон дээд шатны удирдах албан тушаалтанд чиглэсэн сургалт нийт зохион байгуулагдах сургалтын дөнгөж 5 хүрэхгүй хувийг эзэлж байна.

Мөн тус төвийн сургалт хариуцсан бүтэц, нэгжид дотоодын цэргийн алба хаагчийн сургалтыг хариуцсан орон тоо байхгүй нь энэ чиглэлийн сургалт явуулах нөхцөл бололцоогүй, эрх зүйн хувьд чадамжгүй гэж үзэж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Дотоодын цэргийн удирдах ажилтныг бэлтгэх тогтолцоо нь зөвхөн цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны чиглэлээр зохион байгуулагдаж буй сургалт, дамжаанд хамрагдах, мөн батлан хамгаалах салбараас зохион байгуулж буй сургалт, семинарт хамрагдах байдлаар явж иржээ.

Энэ нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болох дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтныг бэлтгэх, сургах үйл явц нь бодлого, чиглэлийн хувьд хөгжөөгүй бусад байгууллагын сургалтад завсрын байдлаар хамрагдаж ирсэн гэж үзэж болохоор байна.

САНАЛ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академид “Дотоодын цэргийн удирдлага, стратегийн тэнхим”-ийг байгуулж, багшийн орон тоо, цалин хөлсний асуудлыг шийдвэрлүүлж, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг батлуулж, сургалтыг эхлүүлэх.

1. Дотоодын цэргийн штабт гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан нэгжийг байгуулж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, гадаад орны ижил төстэй байгууллагатай харилцан хамтын ажиллагааг сайжруулж, урт болон богино хугацааны сургалтад удирдах албан тушаалтныг хамруулах.

2. Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд дотоодын цэргийн сургалт хариуцсан алба хаагчийн орон тоог шинээр бий болгох, дотоодын цэргийн алба хаагчдад чиглэсэн сургалтын эзлэх хувийг нийт сургалтын 30-аас доошгүй хувьд хүргэх.

3. Тус төвийн туршлага, сургалтын базад тулгуурлан Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор /АНУ-ын Элчин сайдын яамаар уламжлуулан “American language course” сургалт/ Англи, Орос, Хятад, Турк гэх зэрэг хэлний хөтөлбөрийг цагдаа, дотоодын цэргийн байгууллагад албан ёсоор хэрэгжүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Дотоодын цэргийн тухай хууль. УБ. 2017.
2. <https://www.uia.gov.mn/>
3. <https://www.internal-troops.police.gov.mn/>
4. <https://police.gov.mn/>
5. “Хууль зүй, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын боловсролын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” эрдэм шинжилгээний эмхэтгэл. УБ. 2022.